



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ АВТОТЭЭВРИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2026 оны 01 дүгээр
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

НЭГ. ЗОРИЛГО

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Зам, тээврийн яамны Автотээврийн бодлого зохицуулалтын газар /АТБЗГ/-ын 2025 оны үйл ажиллагаа, үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, цаашид шийдвэр гаргах түвшинд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналыг сайжруулж, улмаар түүний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангахад оршино.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, мөн оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”, 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

ЗТЯ-ны АТБЗГ-ын 2025 оны үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайд, төрийн нарийн бичгийн даргын тушаал, Зам, тээврийн сайд, аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулсан гэрээ, санамж бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн.

ГУРАВ. БОДЛОГЫН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Хүснэгт 1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилт

Хэрэгжүүлсэн бодлого	Нийт арга хэмжээ	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				Дундаж үнэлгээ (хувь)
		“үр дүнтэй” (85 хувиас дээш)	“үр дүн хүлээгдэж байгаа” (60-84 хувь)	“үр дүн хангалтгүй” (30-59 хувь)	“үр дүн гараагүй” (0-29 хувь)	
Бүсчилсэн хөгжил	1	1	-	-	-	100
Эдийн засаг	3	3	-	-	-	100
Нийт	4	4	-	-	-	100.0

Эх сурвалж: www.new.unelgee.gov.mn

3.2. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

Хүснэгт 2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлт

Хэрэгжүүлсэн бодлого	Нийт арга хэмжээ	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				Дундаж үнэлгээ (хувь)
		“үр дүнтэй” (85 хувиас дээш)	“үр дүн хүлээгдэж байгаа” (60-84 хувь)	“үр дүн хангалтгүй” (30-59 хувь)	“үр дүн гараагүй” (0-29 хувь)	
Аялал жуулчлалын бүс нутгийн автозамын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	1	-	-	-	100.0

 Эх сурвалж: www.new.unelgee.gov.mn

ДӨРӨВ. ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Хүснэгт 3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, 2025 он

№	Зорилт	Зорилтын тоо	Зорилтын эзлэх жин (%)	Арга хэмжээний тоо	Биелэлтийн хувь			Дундаж үнэлгээ (хувь)
					Бүрэн хангалттай	Хангалттай	Хангалтгүй	
1	Ачаа, зорчигч тээврийн тасралтгүй хэвийн байдлыг хангах, тээвэрлэлтийг нэмэгдүүлнэ. Ачаа, зорчигч тээврийн терминал, автобуудал байгуулах, авто зам дагуух үйлчилгээний цогцолбор байгуулна	2	29.0	16	10	3	3	79.0
2	Автотээврийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.	1	20.0	11	5	2	4	74.0
3	Автотээврийн хэрэгслээс үүдэлтэй агаар, орчны бохирдлыг бууруулна.	1	22.0	12	6	4	2	75.0
4	Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих хяналтыг сайжруулна.	1	9.0	5	2	2	1	75.0
5	Салбарын хүний нөөцийг хөгжүүлнэ.	1	4.0	2	2	-	-	100.0
6	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн үйл	1	16.0	9	9	-	-	100.0

ажиллагааг хариуцан ажиллах, хурлыг зохион байгуулж, шийдвэрийг хангуулна.								
Нийт/Дундаж	7	100	55	34	11	10	81.0	

Тайлбар: Нийт 55 арга хэмжээний хэрэгжилтийг харгалзан, зорилт тус бүрийн дундаж үнэлгээг арга хэмжээний тоогоор жинлэн тооцоход хэрэгжилтийн дундаж 81.0 хувьтай байна. Энэхүү дүн нь зорилт тус бүрийн бодит хэрэгжилтийг харгалзан гаргасан жинлэсэн үнэлгээ болно.

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ, 2025 он

№	Арга хэмжээ, зорилт	Биелэлт	Хувь
1	<p>Арга хэмжээ 1.2.1. Алтанбулаг тээвэр, логистикийн төв байгуулах ажлыг эхлүүлнэ. Зорилтот түвшин: IV улирал: Барилгын ажлыг эхлүүлнэ.</p>	<p>Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолд заасны дагуу түншиллээр хэрэгжүүлэх төслийн саналыг уг тогтоолоор баталсан журмын хавсралт маягтын дагуу бэлтгэж, холбогдох хууль, журмын дагуу Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр холбогдох саналыг албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Мөн төр, хувийн хэвшлийн түншиллээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг мэдээлэл, танилцуулгын хамт 03/1129 тоот албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлээд байна. Үүнтэй холбогдуулан түншиллээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журмын 2.3.2, 2.3.3, 2.3.4-т заасан мэдээллийг нэмэлтээр цахим шуудангаар Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Эдийн засгийн хөгжлийн яамнаас түншиллээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээг хянаж, түншиллэлийн гэрээ байгуулах зөвшөөрөл олгоно.</p>	30
2	<p>Арга хэмжээ 1.2.2. Логистикийн төв, ачаа тээврийн терминалууд байгуулна. Зорилтот түвшин: IV улирал: Хавирга боомтод ачаа тээврийн терминалын барилгын ажлыг 30 хувьд хүргэнэ.</p>	<p>Засгийн газрын 2022 оны 447 дугаар тогтоолоор Дорнод аймгийн Чойбалсан сум дахь хилийн Хавирга боомтод Гаалийн хяналтын бүс, чингэлэг тээврийн терминал, гаалийн баталгаат агуулах барих зориулалтаар газар ашиглуулахыг Боомтын сэргэлтийн үндэсний хорооны саналын дагуу Хилийн боомтын захиргаанд ашиглуулах болсон.</p> <p>Тогтоолын хүрээнд Хавирга хилийн боомтын орчимд ачаа тээврийн терминал байгуулах зорилгоор Хилийн боомтын захиргаа болон Ту Ар Эн Си Ложистик ХХК хооронд 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 65 дугаартай гэрээ байгуулсан.</p> <p>Хавирга хилийн боомтод 4.7 тэрбум төгрөгийн өртөг бүхий ачаа тээврийн терминал, 43.3 тэрбум төгрөг өртөг бүхий уурхайгаас хилийн боомт хүртэлх 96 км авто зам, 16 тэрбум төгрөгийн өртөг бүхий хүнд даацын төмөр бетон гүүр, пүү суурилуулах ажлууд хийгдэнэ. Ажлын гүйцэтгэл 20 хувьтай үргэлжилж байна.</p> <p>АХБ-ны хөнгөлөлтэй зээлийн хүрээнд Бичигт хилийн боомтод ачаа, зорчигч тээврийн 24 барилга байгууламж, дэд бүтэц, ногоон байгууламж бүхий</p>	67

		<p>өргөтгөл шинэчлэл, барилга угсралтын ажил явагдаж байна. Мөн зам, гадна инженерийн шугам сүлжээний ажлын хүрээнд авто зам-2,5 км гүйцэтгэл-35%, Барилга угсралтын ажлын явц-5%, Хиймэл байгууламжийн угсралтын ажил -73%, шугам сүлжээний ажил-6 хувийн гүйцэтгэлтэйгээр “Хурдны зам” ХХК гүйцэтгэж байна.</p> <p>АХБ-ны 106,3 сая ам.долларын санхүүжилтээр 2024-2030 онд хэрэгжүүлэх “Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааны төсөл”-ийн хүрээнд хилийн Булган боомтын өргөтгөл шинэчлэлтийн ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 10 хувьтай үргэлжилж байна.</p>	
3	<p>Арга хэмжээ 1.2.5. Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдаж буй зорчигч тээврийн автобуудлын барилгын ажлыг эхлүүлнэ. Зорилтот түвшин: II-III улиралд: барилгын ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэнэ.</p>	<p>ТХХТ-ийн хүрээнд Замын-Үүд автобуудлын барилгыг ЭЗХЯ-аас 2025.03.11-ний өдөр ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд Төр, хувийн хэвшлийн тухай хуулийн дагуу УИХ-аас гаргуулах шийдвэрт тусгуулахаар ажиллаж байна. Уг барилгыг үргэжлүүлэн барих сонирхогч гарахгүй байгаа тул орон нутгийн концессоор хэрэгжүүлэх саналыг Зам, тээврийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/5462 дугаартай албан бичгээр Дорноговь аймгийн Засаг даргад хүргүүлээд байна.</p>	0
4	<p>Арга хэмжээ 2.2. Нийтийн тээврийн автобусыг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгоно. Зорилтот түвшин: IV улирал: Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.</p>	<p>Нийтийн зорчигч тээврийн автобусны хувьд: Нийтийн зорчигч тээврийн зориулалттай 24 болон түүнээс дээш зорчигчийн суудалтай автобусыг гаалийн болон НӨАТ-аас 2025-2027 онуудад (3 жил) чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулан 01/760 дугаар албан бичгээр 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүргүүлсэн. НЗД-аас дэмжсэн тухай хариуг 01/1193 дугаар албан бичгээр 2025.02.24-ны өдөр тус яаманд ирүүлсэн.</p> <p>Мөн уг асуудлаар “Дэмжлэг хүссэн тухай” 01/1210 дугаар албан бичгийг УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороонд 2025.03.20-ны өдөр хүргүүлсэн.</p> <p>Хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан, санал авахаар 01/2300 дугаар албан бичгийг 2025.05 20-ны өдөр ХЗДХ-ийн Сайд, Сангийн сайд нарт хүргүүлсэн.</p> <p>Сангийн сайдаас 01/5133 дугаар албан бичгээр 2025.05.30-ны өдөр өмнөх хуулийн хэрэгжилт, үр дүнг тооцох, эдийн засгийн нөхцөл байдлыг судлан дахин авч үзэх тухай санал ирүүлсэн.</p> <p>Ачааны автомашины хувьд: 2025 оны жилийн эцсийн байдлаар, Монгол Улсад ашиглаж байгаа бензиний 11.7 хувь, дизель түлшний 10.5 хувь нь “Евро-5” стандартын шаардлагыг хангасан шатахуун байна.</p>	50

		<p><i>EVRO IV, V хөдөлгүүртэй, стандартын шаардлага хангасан ачаа тээврийн хэрэгслийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор ачаа тээвэрлэлтийн үйлчилгээнд ашиглаж байгаа тээврийн хэрэгслүүдийн зориулалт, хөдөлгүүрийн ангилал, ашиглалтын байдалд нарийвчилсан эдийн засгийн тооцоолол хийх чиглэлийг “АТҮТ” ТӨҮГ, Нийтийн Тээврийн бодлогын газарт 2025 оны 07/2533 дугаартай албан бичиг хүргүүлсний дагуу холбогдох тооцоо судалгааг хийсэн. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 26 дугаар тэмдэглэлийн 7 дахь заалтаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоод томилолт, өндөр өртөгтэй автомашин зэргийг хязгаарлах шийдвэр гаргасны дагуу нийтийн тээврийн автобус болон ачааны автомашиныг гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх асуудал зогсонги байдалд ороод байна .</i></p>	
5	<p>Арга хэмжээ 2.3. Аюултай ачаа тээвэрлэлтийн чиглэлээр техникийн зохицуулалтыг боловсруулж батлуулна. Зорилтот түвшин: IV улирал: Техникийн зохицуулалтыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.</p>	<p><i>Зам, тээврийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/148 дугаар тушаалаар “Аюултай ачаа авто замаар тээвэрлэх аюулгүй байдлын техникийн зохицуулалт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамжийг батлуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Эрчим хүчний яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эрүүл мэндийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, Цөмийн энергийн комисс, Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газар, “АТҮТ” ТӨҮГ болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл орж ажиллаж байна.</i> <i>Техникийн зохицуулалтын төсөл боловсруулах аргачлалд тусгагдсаны дагуу олон улсын эрх зүйн баримт бичгүүдийг судлан, техникийн зохицуулалтын төслийн эхний хувилбарыг боловсруулан, Ажлын хэсгийн гишүүдээс санал авахаар цахим шуудангаар хүргүүлээд байна.</i></p>	50
6	<p>Арга хэмжээ 2.4. Автотээврийн хэрэгслийн ашиглалт, аюулгүй байдлын техникийн зохицуулалтыг боловсруулж батлуулна. Зорилтот түвшин: III улирал: Техникийн зохицуулалтын төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлнэ.</p>	<p><i>“Техникийн зохицуулалт боловсруулах заавар”-ын дагуу техникийн зохицуулалтын эхний хувилбарын төслийг боловсруулж бэлэн болгосон бөгөөд холбогдох байгууллагуудаас санал авахаар бэлтгэж байна .</i></p>	50

7	<p>Арга хэмжээ 2.6. “Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч бэлтгэх, шалгалт авах, үнэмлэх олгох журам”-ыг боловсруулж батлуулна. Зорилтот түвшин: II улирал: Журам батлуулна.</p>	<p>Мэргэшсэн жолооч бэлтгэх, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулж дууссан. Батлуулахаар бэлтгэж байна.</p>	50
8	<p>Арга хэмжээ 3.1. Ашиглалтаас хасагдсан цахилгаан, хайбрид автомашины өндөр хүчин чадалтай батарейг импортоор оруулахыг хориглох асуудлыг УИХ-д өргөн мэдүүлнэ. Зорилтот түвшин: IV улиралд: Тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.</p>	<p>Бүх төрлийн хайбрид автомашины ашиглалтаас хасагдсан өндөр хүчдэлийн аккумуляторын батарейг импортлохыг хориглох Улсын Их Хурлын шийдвэр гаргуулахаар холбогдох баримт бичгүүдийг боловсруулж байна. Японы Тохокү Их Сургуулийн 2019 онд хийсэн судалгаагаар Монгол Улсад ашиглалтын хугацаа дууссан хосолмол хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл болон литий-ион батарейн хаягдал ойрын ирээдүйд огцом нэмэгдэх эрсдэлтэйг тогтоожээ. Судалгаагаар хосолмол хөдөлгүүртэй хуучин тээврийн хэрэглийн өндөр хүчин чадалтай аккумуляторын батарейн хаягдал 2020-2025 онд 21,000–30,000 орчим байгаа бол 2030 он гэхэд энэ тоо 86,000–107,000 хүрч өсөх хандлагатай байна гэж тооцоолжээ. Хуулийн хэлтсээс хууль тогтоомжийн хүрээнд өгсөн зөвлөмжийн дагуу шардлагатай тооцоо судалгааг гаргаж тогтоолын үзэл баримтлалыг боловсруулан яамны удирдлагад танилцуулав. Удирдлагаас судалгаагаа нарийвчлан боловсруулах үүрэг өгсний дагуу ажиллаж байна.</p>	50
9	<p>Арга хэмжээ 3.2. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт хамрагдах давтамжийг автомашины насжилтаас хамааруулан шинэчлэн тогтооно. Зорилтот түвшин: II улирал: ЗГ-ын 2016 оны 213 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулна.</p>	<p>Засгийн газар шинэчлэн байгуулсантай холбогдуулан Засгийн газрын гишүүдээс дахин санал авч 12 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.</p>	0
10	<p>Арга хэмжээ 4.1. Техникийн хяналтын үзлэгийн төвүүдийг тохирлын үнэлгээнд хамруулна. Зорилтот түвшин: II улирал:</p>	<p>Архангай, Завхан, Увс, Ховд, Баян-Өлгий, Дархан-Уул аймаг дахь техникийн хяналтын үзлэгийн төвүүдийг итгэмжлэлд хамруулах бэлтгэл ажлыг бүрэн хангасан. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирлын 2025 оны 1/367 дугаар албан бичгээр Үндэсний итгэмжлэлийн төвд дээрх аймгуудын Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төвүүдийг</p>	35.2

	<p>Техникийн хяналтын үзлэгийн төвүүдийг тохирлын үнэлгээнд 100 хувь хамруулна.</p>	<p>итгэмжлүүлэх хүсэлтийг холбогдох материалын хамт хүргүүлсэн.</p> <p>“АТУТ” ТӨҮГ-ын захирлын 2025 оны 1/653 дугаартай албан бичгээр Үндэсний итгэмжлэлийн төвд дээрх асуудлаар холбогдох материалын хамт дахин хүргүүлсэн.</p> <p>Хувийн хэвшлийн техникийн хяналтын үзлэгийн /18 төв/ төвүүдээс “Мөнх ерөөлт” ХХК, Идэр улаан хөгжил” ХХК, “Зи э ти” ХХК, “Тайни касл” ХХК, “Монгол терминал” ХХК, “Замт моторс” ХХК, “Доктор авто сүлжээ” ХХК-ийн Хан-уул, Нарны зам салбарууд тус тус тохирлын үнэлгээнд хамрагдаж итгэмжлэл авсан байна.</p>	
--	---	--	--

4.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хүснэгт 5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн, 2025 он

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
43	28	14	-	-	1	83.3

Эх сурвалж: www.new.unelgee.gov.mn

4.3. Сайдын тушаалын хэрэгжилт

Хүснэгт 6. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт, 2025 он

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
23	19	3	-	1	-	93.2

4.4. Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт

Хүснэгт 7. ТНБД-ын тушаалын хэрэгжилт, 2025 он

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
26	24	2	-	-	-	96.1

ТАВ. ЧАДАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

5.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээ, санамж бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт

Хүснэгт 8. Гэрээ, санамж бичгийн хэрэгжилт, 2025 он

		Хэрэгжилтийн хувь	
--	--	-------------------	--

Аймаг, нийслэл	Арга хэмжээ	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	Үнэлгээний дундаж (хувь)
		100%	50%	0%			
Нийслэл	7	4	1	1	1	-	75.0
Архангай	6	3	1	2	-	-	58.3
Баян-Өлгий	7	7	-	-	-	-	100.0
Баянхонгор	7	1	5	1	-	-	50.0
Булган	7	2	5	-	-	-	64.3
Говь-Алтай	7	4	3	-	-	-	78.6
Говьсүмбэр	7	4	3	-	-	-	78.6
Дархан-Уул	7	4	2	1	-	-	71.4
Дорноговь	7	5	2	-	-	-	85.7
Дорнод	7	6	1	-	-	-	92.9
Дундговь	7	4	3	-	-	-	78.6
Завхан	7	-	7	-	-	-	50.0
Орхон	7	4	3	-	-	-	78.6
Өвөрхангай	7	2	3	1	-	1	58.3
Өмнөговь	7	4	2	1	-	-	71.4
Сүхбаатар	7	-	7	-	-	-	50.0
Сэлэнгэ	7	5	2	-	-	-	85.7
Төв	6	1	3	2	-	-	41.7
Увс	7	6	1	-	-	-	92.9
Ховд	7	5	-	2	-	-	71.4
Хөвсгөл	7	2	5	-	-	-	64.3
Хэнтий	7	4	3	-	-	-	78.6
Нийт	152	77	62	11	1	1	72.0

Хэрэгжээгүй ажлуудыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9. Хэрэгжээгүй ажлууд, 2025 он

д/д	Нэр	Гэрээнд хэрэгжүүлэхээр тусгасан ажил
1	Нийслэл	Тусгай замын автобус (BRT)-ны сүлжээ байгуулах төслийг хэрэгжүүлнэ.
2	Архангай	Хот хооронд, орон нутгийн ачаа тээвэрлэлтийг бүртгэлжүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавина.
		Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэг, авто үйлчилгээ, жолоочийн болон тээврийн хэрэгслийн даатгалд хамрагдах асуудалд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.
3	Баянхонгор	Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих, олон нийтийг мэдээллээр хангана.
4	Дархан-Уул	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах тухай” 189 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Олон улс, улсын чанартай авто зам дагуух ариун цэврийн байгууламж бүхий үйлчилгээний цогцолборын байршлын жагсаалт”-д дурдсан байршилд төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжүүдэд газар олгох асуудлыг шийдэх, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг мэдээллээ улирал бүр гаргаж ирүүлнэ.
5	Өвөрхангай	Хот хооронд, орон нутгийн ачаа тээвэрлэлтийг бүртгэлжүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавина.
6	Өмнөговь	Аймаг, орон нутагт автотээврийн хэрэгслийн ашиглалтаас хасагдсан аюултай хог хаягдал /шингэн болон бүх төрлийн аккумуляторын батарей/-ыг цуглуулах,

		хадгалах шаардлага хангасан цэгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй хамтран байгуулах, хэрэгжилтийн үр дүнг улирал бүр мэдээлнэ.
7	Төв	Сум, орон нутагт автотээврийн хэрэгслийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний цахим үйлчилгээг нэвтрүүлэх бүртгэлийн байгууллагад дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.
		Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэг, авто үйлчилгээ, жолоочийн болон тээврийн хэрэгслийн даатгалд хамрагдах асуудалд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.
8	Ховд	Аймаг, орон нутагт автотээврийн хэрэгслийн ашиглалтаас хасагдсан аюултай хог хаягдал /шингэн болон бүх төрлийн аккумуляторын батарей/-ыг цуглуулах, хадгалах шаардлага хангасан цэгийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй хамтран байгуулах, хэрэгжилтийн үр дүнг улирал бүр мэдээлнэ.
		Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайд, Эрчим хүчний сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нарын 2024 онд баталсан "Цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх" төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн үр дүнг улирал бүр гаргаж ирүүлнэ.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

ЗТЯ-ны АТБЗГ-ын 2025 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тус газрын ерөнхий үнэлгээ нь 90.0 хувьтай байна. Энэ нь өмнөх оны үнэлгээний дунджаас 6.7 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үнэлгээний үндсэн 3 үзүүлэлтээр бодлогын үр дүнгийн үнэлгээний жинлэсэн дундаж 100 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээний жинлэсэн дундаж 86 хувь, чадамжийн үнэлгээний жинлэсэн дундаж 72 хувьтай байна.

Хүснэгт 10. Ерөнхий үнэлгээ, 2025 он

Үзүүлэлт		Хэрэгжилт (хувь)
1	2	3
Бодлогын үр дүн	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100.0
	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	100.0
Чиг үүргийн үзүүлэлтийн дүн	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	81.0
	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	83.3
	Сайдын тушаалын хэрэгжилт	93.2
	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт	96.1
Чадамжийн үнэлгээ	Зам, тээврийн сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээ, санамж бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт	72.0
Ерөнхий дүн (жинлэсэн дундаж)		90.0

Үнэлгээний үзүүлэлт бүрийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 0.4, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 1, сайдын тушаалын хэрэгжилт 12.2, төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт 8.2 нэгж хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний хэрэгжилт "хангалтгүй" гэж дүгнэгдсэн нь төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр шийдэгдээгүй, хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, тухайн арга хэмжээний шалгуур үзүүлэлт нь зорилт, арга хэмжээтэй уялдаагүй, бусад байгууллагаас зөвшөөрөл олгох, хамтран хэрэгжүүлэх үйл явц удаашралтай зэрэг шалтгаантай холбоотой гэж дүгнэлээ.

Зам, тээврийн сайдаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд биелэлт хангалтгүй, явц, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж улмаар биелэлтийг хангуулах талаар зохион байгуулалтын үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, гэрээ байгуулсан талуудын хамтын ажиллагаа сул зэрэг нөхцөл байдал тогтоогдлоо.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

АТБЗГ-ын 2025 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн бодлого, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Зөвлөмж болгож байна. Үүнд:

7.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай ажил, арга хэмжээг эрэмблэн тусгаж хэрэгжүүлэх;

7.2. Цаашид бодлогын баримт бичиг, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, хэрэгжилт удаашралтай, хангалтгүй арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

7.3. Бодлогын баримт бичиг, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүрсэн эсэхийг нотлох баримтад үндэслэн үнэн зөв тайлагнаж ирүүлж байх;

7.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хангуулах ажлын хүрээнд “хэрэгжих шатанд” буюу удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн 62, “хэрэгжээгүй” 11, “хэрэгжих боломжгүй” 1, нийт 74 арга хэмжээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцлийг тогтоох, 2026 оны гэрээнд тусгагдах арга хэмжээнүүдийг заалт, хүрэх түвшин бүрээр нарийвчлан зөвшилцөж, нягтлан батлуулж, хэрэгжилтийг хангуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;

7.5. Автотээврийн салбарын үйл ажиллагаанд ногоон хөгжил, цахимжилт, процессийн дахин инженерчлэл, хиймэл оюун, эрсдэлд суурилсан бодлого зэрэг орчин үеийн хөгжлийн чиг хандлага, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлж, бодлогоор хангах;

7.6. Автотээврийн салбарын төрийн үйлчилгээг бүрэн цахимжуулах, үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах замаар иргэд, олон нийтийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, аливаа эрсдлийг бууруулах, төрийн бусад цахим үйлчилгээтэй шууд холбогдож мэдээлэл солилцдог API (Application Programming Interface) суурьтай интеграцийг хөгжүүлэх замаар Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Digital nation”, “Digital First” стратеги, хөтөлбөрийн зорилтыг салбарын хэмжээнд хангуулах талаар бодлого тодорхойлон хэрэгжүүлэх;

7.7. Газрын дутуу орон тоог нөхөж албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг нэмэгдүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;

“СХШУДАГ

